



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/03

Булган сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, зөвшөөрөл олгох тухай Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 527 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн, гүйцэтгэлийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/488 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай

4.Албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Д.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

